

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах Ерөнхий шаардлага	MNS 6258-1 : 2011
Planting and pitting seedlings hole, General requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь хот, суурин газрын нийтийн эзэмшил, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайг цэцэрлэгжүүлэхэд суулгацын нүх бэлтгэх, суулгахад хамаарна.

## 2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 6139 : 2010, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- MNS 6141 : 2010, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 24835 : 81, Мод, сөөгний суулгац. Техникийн шаардлага.

## 3 Нэр томъёо, тодорхойлолт

### 3.1

#### Мод

Титэм бүхий гол иштэй модлог ургамал.

### 3.2

#### Сөөг

Гол ишгүй, үндэсний хүзүүнээс дээш адил хэмжээний олон иштэй 5 метр хүртэл өндөр ургадаг модлог ургамал.

### 3.3

#### Тарьц

Мод үржүүлгийн газарт үр болон мөчрөөр ургуулсан 1-ээс 2 настай модлог ургамал.

### 3.4

#### Суулгац

Бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж ургуулан 2-оос дээш настай модлог ургамал,

## 4 Суулгацын нүхийг бэлтгэх

## MNS 6258-1 : 2011

MNS 6139:2010, Шилмүүст модны суулгац. Техникийн шаардлага, MNS 6141:2010, Навчит модны суулгац. Техникийн шаардлага стандартуудыг хангасан суулгацын нүхийг 1-р хүснэгтэд заасан хэмжээгээр ухсан байна.

### Суулгацын нүх бэлтгэх хэмжээ


1-р хүснэгт

№	Суулгацын материалын нэр	Нүхний хэмжээ (м)	
		голч	гүн
1	Шилмүүст модны суулгац	1,2-1,5	1,0
2	Навчит модны суулгац	1,2-1,5	0,8
3	Хэсэгчилсэн ба ганцаарчлан суулгасан бут, сөөг	0,7	0,5
4	Бут сөөгний 2 эгнээгээр суулгасан ургамлан хашлагын шуудуу	0,4-0,5	0,4
5	Мод, сөөгний үндэсний шороотой суулгах хэмжээ (м)	0,5	0,4
		0,7	0,5
		0,9	0,6
		1,0	0,7
		1,3	0,8
		1,5	0,8
		1,7	1,0

## 5 Суулгацыг суулгах

**5.1** Хот суурин газрыг цэцэрлэгжүүлэхэд зориулсан суулгацыг хавар 4 дүгээр сарын 15-аас 5 дугаар сарын 25 хүртэл, намар 10 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 1 хүртэл хугацаанд суулгана.



**5.2** Модны суулгацыг нүхний голд байрлуулан үндэсний хүзүүг газрын түвшингээс 5-аас 10 см-ээс ихгүй гүнд суулгаж, нүхэнд шороог бага багаар хийж, үндэсний хүзүү хүртэл дүүргэн нягтруулсны дараа ханатал усалсан байна.



1-р зураг. Суулгацыг суулгах байдал

**5.3** Суулгацын үндсийг нугалахгүйгээр жигд тарааж суулгана.

**5.4** Суулгасан модыг салхинаас хамгаалж модны 2 буюу 3 талд гадас хатгаж, модны ишийг титэмийн доогуур зөөлөн материалаар ороож, гадаснаас бэхлэн уяна.



2-р зураг. Модыг бэхэлсэн байдал

**5.5** Мод тарьсан тогоо ны хана нь 5-аас 10 см өндөртэй байна. 1 модыг 60-аас 80 л усаар усална.

**5.6** Мод услах тогоог эхний гурван жил тогтмол цэвэрлэж, зэрлэг ургамлыг устган, хөрсийг сийрүүлж байвал зохино.

**ТӨГСӨВ.**